

Иргэний эрх зүй

**МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ТҮҮХЭН
ХӨГЖИЛ,ТӨЛӨВШИЛ: ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА**

**HISTORICAL DEVELOPMENT AND FUTURE TRENDS OF THE SCIENCE
IN CIVIL LAW OF MONGOLIA**



Ж.Ууганчимэг

*Дотоод хэргийн их сургуулийн
Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн
Хувийн эрх зүйн тэнхимийн дэд профессор,
докторант, ахмад*

Товч агуулга: Энэ удаад та бүхэнд хувийн ба нийтийн эрх зүйн ялгаатай талыг тодорхойлж,иргэний эрх зүйн шинжлэх ухааны хөгжлийн үе шатны талаар судалгаа хийж, цаашид хувийн эрх зүй тэр дундаа иргэний эрх зүйг хэрхэн төгөлдөржүүлэх, түүний хөгжлийг түргэсгэх, зарим нэг тулгамдсан асуудлыг тодорхойлж шийдвэрлэх талаар санал дэвшүүлэхийг зорилоо.

Abstract: This time, I would like to identify the differences between private and public law, conduct research on the stages of development of the science of civil law, and make suggestions on how to improve private law, including civil law, and accelerate its development, and identify and solve some pressing issues. aimed.

Түлхүүр үг: Хувийн эрх зүй, иргэний эрх зүй, нийтийн эрх зүй, даяаршил

Key word: Private law, civil law, public law Globalization

Оршил:

Хувийн эрх зүй нь тэгш эрхтэй эрх зүйн этгээдүүдийн хооронд үүссэн харилцааг зохицуулж буй эрх зүйн нэг салбар юм. Харин нийтийн эрх зүй нь эсрэгээрээ босоо харилцаа буюу захирах, захирагдах харилцааг зохицуулдаг.

Юуны өмнө хувийн эрх зүй ба нийтийн эрх зүйн ялгаатай байдлыг тайлбарлая.

1. Аливаа хэрэг хувийн эрх зүй, эсвэл нийтийн эрх зүйн дагуу шийдвэрлэгдэх нь тухайн тохиолдолд ямар эрх зүйн хэм хэмжээ хэрэглэгдэхээс хамаардаг.

2. Нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх шүүхийн харьяаллаараа ялгаатай байдаг.

Хувийн эрх зүй нь нийгмийн ашиг сонирхлын ухаалаг тэнцвэрийг тогтоох ба дэмжих, эрчимтэй хөгжиж буй нийгмийн харилцааг аль болох уян хатан болгох, хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэн хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэсэн, гүйцэтгэсээр ч байх бөгөөд аж ахуйн үйл ажиллагаа, зах зээлийн эдийн засгийн үндэс болдог билээ¹¹².

Хувийн эрх зүй буюу иргэний эрх зүйн хөгжлийн суурь нь эртний Ромын эрх зүйгээс үүдэлтэй бөгөөд Ромын иргэд эд хөрөнгөө өмчлөх, эзэмших эрхтэй гэсэн үзэл сэтгэлгээ бий болж улмаар нь тэр нь эрх зүйгээр баталгаажин эрх зүйн системд **JUS CIVIL** буюу хувийн эрх зүйн гол цөм болох иргэний эрх зүйн салбар болон үүсэн хөгжсөөр бидний үед хүрч ирсэн.

Үндсэн хэсэг:

Иргэний эрх зүй нь хууль зүйн шинжлэх ухааны салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд хувийн эрх зүйн голлох буюу тэргүүлэх салбар юм. Уг эрх зүйн салбар нь бие даасан нэгэн салбар төдийгүй бусад олон салбар эрх зүйтэй харилцан шүтэлцээтэй байх ба зарим эрдэмтдийн томьёолсноор иргэний хууль нь “бага үндсэн хууль” гэж нэрлэгддэг.

Монгол улсын Иргэний эрх зүйн хөгжлийн үе шатыг дараах байдлаар авч үздэг¹¹³.

Эртний үеийн иргэний эрх зүй

Дундад зуухны үеийн иргэний эрх зүй

Шинэ үеийн иргэний эрх зүй

Нэн шинэ үеийн иргэний эрх зүй

Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлд “төрт ёс, түүх, соёлынхоо уламжлал”-ыг нандигнан хөгжүүлэхийн ач холбогдлыг тунхаглан заасан нь эрх зүйн шинжлэх ухааны хөгжилд шууд хамааралтай юм.

Иргэний эрх зүй нь хууль зүйн шинжлэх ухааны салшгүй бүрэлдэхүүн хэсэг, түүний бие даасан нэгэн салбар төдийгүй бусад олон салбар эрх зүйтэй харилцан шүтэлцээтэй байхаас гадна тэдгээрийн нэг эх сурвалжид хамаарч байдгаараа зарим эрдэмтдийн томьёолсноор “бага үндсэн хууль” гэж нэрлэгддэг. Иргэний эрх зүйн субъект нь бусад салбар эрх зүйн субъектээс үлэмж өргөн бөгөөд тэдгээрийн эрх үүргийн үндсэн шинж нь ямар нэгэн ялгаваргүй адил тэгш байх зарчимд тулгуурласан байх, нөгөө талаар үндэсний болон олон улсын хэмжээнд

¹¹² С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг. УБ 2005 он., 537 дугаар тал.

¹¹³ Ж.Ууганчимэг. “Иргэний эрх зүйн лекцүүд” УБ., 2012 он 12 дугаар тал.

бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн эрх зүй, зан үйлийн уламжлал дэвшлийг хүлээн зөвшөөрч, улмаар иргэний хууль тогтоомж төдийгүй шүүх, арбитрын байгууллагын практик үйл ажиллагаагаар баталгаажин хэрэгждэгээрээ онцлогтой. Монгол Улсын Иргэний эрх зүй нь олон улсын иргэний эрх зүйтэй уламжлан хөгжиж ирсэн гэж үзэж болно. Гагцхүү иргэний эрх зүй төдийгүй бусад салбар эрх зүй, төр, нийгмийн түүх нь хэзээ ч ямар ч нөхцөлд уламжлал, шинэчлэлийн замаар тасралтгүй үргэлжлэх үйл явц юм.

Монгол Улсын төр, эрх зүйн үүсэл, хөгжлийн түүхэн үйл явцыг судалсан эрдэмтдийн бүтээлээс үзвэл монголчуудын хууль зүйн хэм хэмжээг аман, бичмэл хоёр хэлбэрээр илэрч хэрэгжиж ирснийг хүлээн зөвшөөрдөг. Аман хэлбэрийн хууль зүй нь хаад, ноёдын болон шашны үзэл сургаал, хориг, дэг, түүнчлэн үлгэр домог гэх мэт хэлбэртэй байсан бол бичгийн хэлбэрийн хууль цааз нь эзэн богд Чингис хааны Их засгаас эхлэлтэй гэж эрдэмтэд баталсан байдаг. Энэ тухай “БНМАУ-ын түүх” номын 143-р талд “13, 14-р зууны үед монголчуудын хууль зүйн мэдлэг, мэдэгдэхүйц хөгжиж иржээ. 13-р зууны эхээр гарсан Монголын анхны бичигдмэл хуулийн хураамж “Их жасаа” Их засаг юм. Их засаг бол монголын төр, захиргаа, цэрэг эрүү шүүлт, иргэн, худалдаа, хэв ёсны хуулийн хураамж бичиг байжээ. Монголын анхны хураамж бичгийг боловсруулах, ерөөсөө их гүрний хууль цаазын үйл ажиллагаанд Монголын тулгар төрийн анхны “Заргач” /шүүгч/ хууль зүйч татарын Шихи хутуг /1180-1262/ чухал үүрэг гүйцэтгэжээ” гэж тэмдэглэжээ¹¹⁴.

Эрдэмтэн Н.Ням-Осор эзэн Чингисийн Их засаг хуулийн тайлбар / “ёс заншил бол ёслон биелүүлэх хууль мөн” /номын 102-р тал/. Их засаг хууль нь өөрийн үеэс өмнөх аман хэв хуулиудад суурилсан, тэдгээр хэв хуулиуд нь ард түмний ёс заншлаас ургаж гарсан бөгөөд цаашдаа хууль, эрх зүйг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн гэж онцлон дурджээ.

“Монголын нэгдсэн төрийн болон дараа үеийн хууль цааз, заншлын хэм хэмжээг харьцуулан судалсан нь” бүтээлдээ эрдэмтэн Б.Баярхүү “Монголын эртний хуулиудад заншлын хэм хэмжээ хэрхэн тусгалаа олж хөгжсөн, улмаар хууль зүйн хэм хэмжээ, заншлын хэм хэмжээ болж хувирсныг хууль зүйн үүднээс харьцуулж, түүхчлэн дүгнэсэн байна.

Б.Чимид “Их Чингисийн байгуулсан тулгар төрийн үе 12-р зууны эцсээс 20-р зууны эхний 20 жил хүртэл Монгол их, бага олон үеийн хаант засгийг дамжин хөгжсөн феодалын эрх зүйт орон байв. Бурхны номлол, хаадын зарлиг, заншил, шашин сүм, хийдийн хэм хэмжээнээс бүрдсэн эрх зүйн тогтолцоо байсан. Манж Чин улс Монголыг ноёрхсон 220 гаруй жил манж, Хятадын хуулийг хүчээр дагуулснаас үндэсний уламжлал ихэд суларч, тасалдсан” гэж /Прокурорын ном, 2001 оны 145-р тал/ тэмдэглэжээ.

Иргэний эрх зүйн олон талт харилцаа нь хууль зүйн хэлбэрээр бие даасан эрх зүйн эх сурвалжийн хэмжээнд хүртэл боловсрогдон батлагдаж ирсэн гэх баримт олдоогүй ч Монгол Улсад төрт ёс үүсэн тогтож хөгжиж ирсэн түүхэн үе

¹¹⁴Ж.Болдбаатар, Ж.Лүндээжанцан “Монголын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 1997., 14 дэх тал

шат бүрд нийгмийн амьдралаас уламжлан залгамжилж хадгалагдаж ирсэн баримт сурвалж цөөнгүй байдаг.

Өөрөөр хэлбэл тухайн үеийн төр нийгмийн харилцааг зохицуулж байсан нэгдмэл хууль тогтоомжид ямар нэг хэлбэр, хэмжээгээр тусгалаа олж хамгаалагдан бэхжиж, эрх зүйн шинжлэх ухааны салбарт зохих байр суурь эзэлсээр ирсэн гэж үзэх үндэслэлтэй юм. Эрдэмтэн Н.Ням-Осорын бүтээл “13-р зууны Монголын нийгэм, эдийн засгийн амьдралд Чингис хааны “Их засаг” хуулийн гүйцэтгэсэн үүрэг юм”¹¹⁵.

Египетийн түүхч Магриз, Хятадын эрдэмтэн Сайшаал болон бусад олон эрдэмтэн судлаачдаас “Их засаг” хуульд аж ахуй, арилжаа, худалдаа, ан ав, байгаль орчноо хамгаалах зэрэг ёс горимыг тогтоосон бүхэл бүтэн бүлэг бий гэж тодорхой баримтаар дурдсан байдаг. Тухайлбал, байгаль орчны эд агуурс баялаг ан амьтдыг зөвхөн өөрийн эзэмшлийн газар нутгаас авч ашиглаж байх, амьтдыг үржил төллөлтийн үед авлах, тэр байтугай шувууны үүрэнд сүүдрээ тусгахыг хүртэл цээрлэж байх. Арилжаа, худалдаа шударгаар явуулах, бусдыг хуурч мэхлэх, эд агуурсыг өндөр үнээр дамлахын хориглох, олсон олз, ашгаас татвар, хураамж төлж байх, өртөө харуулын албыг эрхлэн гүйцэтгэж түүний зардал, уналгыг адил тэгш хангаж байх, малын үүлдэр, угсаа, үр шимийг сайжруулах зэрэг иргэний эрх зүйд хамаарах олон бүлэг асуудлыг хуулиар зохицуулж байсан баримт байна. Түүгээр ч барахгүй аливаа хэрэг, зөрчил гаргасан этгээдийг мал, эд зүйлээр торгож байсан нь эрүүгийн ял төдийгүй мөн иргэний эрх зүйн журмаар “хохирол нөхөн төлүүлэх” хэм хэмжээтэй адил давхцаж байсан гэж үзэх үндэслэлтэй юм.

Их засаг цаазын нэг онцлог бол ялангуяа иргэний эрх зүйн гол зарчим болох “тэгш эрхийн” тухай асуудлыг түүнчлэн эд хөрөнгийн эрхийг өвлөх, залгамжлах эрх, үүргийн талаар нэн тодорхой нийтлэг хэм хэмжээ тогтоосон байдаг.¹¹⁶ Жишээлбэл, эрх мэдэл өндөр, эд хөрөнгө ядуу хоосон гэж ангилан ялгаж болохгүй. Бодгаль бүр адил тэгш үүрэгтэй байхыг хуульчлан тогтоож байжээ. Түүнчлэн хэн нэгнийг нас барсан нөхцөлд түүний гэр бүлийн гишүүд төдийгүй, хөлсөөр ажиллагсад, зарцлагдаж байсан хүмүүст нас барагчийн эд хөрөнгөнөөс заавал хувь хүртээж, өв үлдээж өгч байх журмыг тогтоосон байна. 1640 оны Халх журам хууль бол Монгол Улсын төр, нийгэм, хууль зүйн шинжлэх ухааны түүхэнд чухал эх сурвалж болох бие даасан бүтээл гэж тэмдэглэгддэг. Энэ хууль нь тухайн үеийн Монгол орны аж ахуй, эдийн засаг, улс төр, нийгмийн байдлаас урган гарсан эхлэлтэйгээрээ онцлогтой эрх зүйн баримт бичиг болно.

Ц.Жамсранов, Ц.А.Трунов, Б.Е.Владимирцов, А.В.Рязновский нарын бүтээлд тэмдэглэснээр Халх журам бол нүүдлийн феодализмын нийгмийн харилцааг зохицуулахад шууд чиглэсэн хэв заншлын хуулийн цуглуулгын шинжтэй эрх зүйн баримт бичиг юм. Халх журам бол эрдэмтэн С.Жалан-Аажавын тодорхойлсноор төрийн захиргааны, иргэний, эрүүгийн гэх мэт тулгуур болон салбар олон төрлийн эрх зүйд ангилан үзэж болох юм. С.Жалан-Аажав өөрийн бүтээлдээ “худалдаа, арилжааны өр авалга, өв залгамжлал, гэр бүлийн зэрэг

¹¹⁵ Б.Я.Владимирцов. Чингис хаан.УБ.,1996.14 дэх тал

¹¹⁶ Э.Авирмэд.,Г.Совд.,Д.Дашцэдэн. Монгол хууль.,УБ.,1997. 6 дахь тал

иргэний эрх зүйд хамаарах олон зүйл, заалтыг Халх журамд тусган хуульчилсан гэж тодорхойлжээ. Мөн профессор Ш.Нацагдорж, С.Жалан-Аажав нар өөрсдийн бүтээлдээ Халх журам хуулийг Чингисийн Их засаг, Улаан хацарт гэх шавь яамны таслан шийтгэсэн зэрэг олон эх сурвалж болох түүхэн баримт бичгээс уламжлалтай бөгөөд тэдгээрийг харьцуулан судлах нь нэн чухал гэж тэмдэглэсэн байдаг¹¹⁷.

1921 оны ардын хувьсгалын өмнөх Монгол оронд хар шар феодалын эрх ашиг, сонирхлыг хамгаалсан эрх зүйн тогтолцоо үйлчлэн зохицуулж байсныг батлах олон эх сурвалж байдаг. Тухайлбал, ОХУ-ын монголч эрдэмтэн зохиолч, академич И.Я.Златкин “Монгол улсын нэн шинэхэн үеийн түүхийн тухай” бүтээлдээ “богд гэгээний засгийн газар, автономит Монголд манжийн хууль тогтоомж, манжийн үеийн язгууртны шүүх, өөрөөр хэлбэл, лам, феодал мөн хамжлага ард, шавь нарт тус тусад нь байгуулсан шүүхийг хөндсөнгүй, засаг захиргаа, цэрэг, шүүхийн хэрэг хуучнаараа хошууны засаг ноёны бүрэн эрхэд хэвээр хадгалагдан үлдсэн байв” гэж тэмдэглэжээ.

Үүнээс үзэхэд иргэний төдийгүй, аль төрөл, салбарын эрх зүй нь манжийн хааны зарлиг хуульд тусгалаа олж хэрэгжиж ирсэн гэж үзэх үндэслэлтэй байна.

Монгол Улсын ардчилсан шатны үе дэх иргэний эрх зүй /1921-1960/
БНМАУ-ын анхдугаар Их хурлаас 1924 онд баталсан Үндсэн хууль нь иргэний эрх зүйн төдийгүй бусад салбар эрх зүйн гол эх сурвалж болсноороо МУ-ын иргэний хууль тогтоомжийг боловсруулах, батламжлах нөхцөл бололцоог бүрдүүлсэн байна. Үндсэн хуульд тус орны хамжлагат ёсыг халж, хөрөнгөтний бус замаар хөгжүүлэх, ардчилсан шинэ тогтолцоог бүрдүүлэх талаар заасан зорилт, зарчмууд нь иргэний хууль тогтоомжид шууд тусгалаа олж хуульчлагдсан юм. Аливаа хууль тогтоомж бол хэн нэгэн эрдэмтэн мэргэн эсвэл эрх мэдэлтний хүсэл санал, үзэл бодлоор биш харин тухайн төр, нийгэм, эдийн засгийн зайлшгүй тулгамдсан хэрэгцээ шаардлагын хүрээнд боловсрогдон батлагдаж, дагаж мөрдөгдөх жам ёсны зүй тогтолтой ажээ. Тухайлбал, 1926-1929 онуудад хэсэгчлэн боловсруулж, тухай бүр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн баталсан БХМАУ-ын Иргэний хууль нь тухайн цаг үеийнхээ нөхцөл байдалд шаардагдсан гол гол харилцааг зохицуулахад шууд чиглэсэн байв. Энэ хугацаанд батлагдсан 10 бүлэг 217 зүйл бүхий Иргэний хуулиар зохицуулж ирсэн гол харилцааг дараахь байдлаар утгачлан тайлбарлаж болох юм. 1/Тухайн үеийн иргэний эрх зүйн харилцааны гол субъект нь иргэд, тэр дундаа эд хөрөнгийн хувьд ядуу дорой аж амьдрал бүхий хүмүүсийн эд хөрөнгийн болон амин хувийн ашиг сонирхлыг хамгаалах асуудлыг тэргүүн зэргийн зорилт болгон баталгаажуулсан байв. 2/Аливаа эд хөрөнгийг эзэмших, ашиглах эрхийг уламжлан хадгалах, тухайлбал, хар шар феодал, ноёдын эд хөрөнгийг хураан авах буюу худалдах, шилжүүлэх аргаар улсын буюу иргэдийн өмчлөлд шилжүүлэх журмыг тогтоон хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн байна. 3/Төр, нийгмийн үүр үндэс болох гэр бүл бологсод болон тэдний гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн болон амин хувийн эрх, эрх чөлөөг адил тэгш хамгаалах зарчмыг тогтоож, гэр бүлийн харилцаан дахь хоцрогдлыг арилгахад шууд чиглэсэн хэм хэмжээг тогтоон хэрэгжүүлсэн. 4/ Хууль тогтоомжоор эрх мэдэл нь

¹¹⁷Т.Мөнхжаргал “Монгол Улсын Иргэний цаазын товчоон” УБ.,2006 он 10 дахь тал

ямар нэг хэлбэрээр хязгаарлагдаагүй иргэн, албан хаагч хэн боловч олон нийтийн байгууллага, эвлэл хоршоонд гишүүнээр нэгдэн орох эрхийг хуульчлан баталж өгсөн. 5/Аливаа хөрөнгө хогшлын тухай гэсэн бүлэгт өнөө үеийн өмчийн хэлбэр, төрөл, мөн үүрэг үүсэх үндэслэл, үүргийн гүйцэтгэлийг хангах арга, журам, зарчмыг тухайн үеийн эрх зүй, эдийн засгийн ойлголтын хүрээнд томъёолон тодорхойлсон. 6/Аливаа өр ширийг арилгах гэсэн бүлэгтээ иргэний эрх зүйн харилцаанаас үүссэн өр авлагыг барагдуулах арга журмыг захиргааны болон шүүхийн журмаар шийдвэрлэх зарчмыг тогтоон өгсөн байна. 7/Эл хуульд аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах, эд хөрөнгийг барьцаалах, гэрээ хэлцэл хийх болон түүний үр дагаврыг тооцох хууль зүйн үндэслэлийг тодорхой заасан байв. 8/Иргэний эрх зүйн харилцаанаас үүссэн маргааны талаар эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг биелүүлэх, давж заалдах зэрэг иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдсон эрх зүйн үндэслэлийг өөртөө агуулж хуульчлан заасан байлаа.

Энэхүү Иргэний хуулийг 1952 он хүртэл дагаж мөрдсөн бөгөөд түүний гүйцэтгэсэн гол үүрэг, ач холбогдлыг тодорхойлбол: 1/1921 оны ардын хувьсгалын ялалт, ардчилсан төрийн тогтолцоо, нийгмийн ололт амжилт, иргэний эрх, эрх чөлөөг хамгаалах болон хуучин феодалын нийгмийн харилцааг халж солих, тухайлбал, урьдах нийгмийн үеийн эрх тэгш бус хууль цаазыг өөрчлөн шинэчлэх, 2/тухайн нийгмийн үе дэх гэр бүл, ахуй соёлын харилцаан дахь хоцрогдол, дарангуйллын ул мөрийг арилгаж, ардчилсан шинэ дэвшилтэт ёс суртахууны харилцааг үүсгэн тогтоох нөхцөлийг бүрдүүлэх, 3/хөрш зэргэлдээ ЗХУ болон хөгжилтэй зарим орны хууль зүйн түүхэн туршлагаас судалж, суралцах, түүнээс үлгэр дуурайл авч хууль тогтоомжийн хэлбэр, загвар, агуулгыг дэлхийн олон улсын түвшинд хүртэл боловсронгуй болгох эх үндсийг тавих, 4/хар, шар феодал, ноёд, түшмэдийн гарт зонхилон төвлөрсөн өмч хөрөнгийг улсын болон иргэдийн мэдэлд шилжүүлэх, эд хөрөнгийн эрх үүргийг аль болох адил тэгш байх зарчмыг тусгах, 5/Монгол Улсын төрт ёсны түүхэнд анх удаа гэж хэлж болохоор иргэний эрх зүйн бие дааж системчлэгдсэн Иргэний хуулийг батлан мөрдүүлснээрээ хууль зүйн шинжлэх ухааны түүхэнд чухал баримт бичиг эх сурвалж болсон гэж үзнэ.

Мөн 1952 онд Иргэний байцаан шийтгэх хууль батлагдаж дагаж мөрдсөнөөр аливаа иргэний хэрэг маргааныг шүүхээс хянан шийдвэрлэх дэг журмыг хуульчлан баталгаажуулсан төдийгүй эрх зүйн салбар дахь нэг шинэ төрөл болон хөгжих үндэс тавигдсан болно.

Социалист байгууллагын үе дахь иргэний эрх зүй /1960-1990он/

Олон улсын эрх зүйн тогтолцоонд социалист эрх зүйн тогтолцоо нь чухал байр суурь эзэлж бие даасан нэгэн хэсэг болж судлагддаг билээ. Социалист эрх зүйн тогтолцооны нэг бие даасан салбар нь социалист иргэний эрх зүй юм. Социалист иргэний эрх зүйн тогтолцоог 1960-аад онд ЗСБНХУ, БНМАУ, БНХАУ, БНУАУ, БНКУ гэх зэрэг Ази, Европ, Америк тивийн тухайлбал, дэлхийн 2-р дайны дараа бүрэлдэн тогтсон социалист чиглэлийн төр, нийгэм эдийн засгийн байгуулал бүхий 10 гаруй улс орныг хамааруулан үздэг.

Социалист тогтолцоо бүхий тэдгээр улс орнуудын тухайд төр, нийгмийн байгууламж эдийн засгийн харилцаа бараг нэгдмэл нэг стандартчилагдсан эрх зүйгээр зохицуулж ирснээрээ онцлогтой. Социалист эрх зүйн тогтолцооны гол эх сурвалж нь Эдийн засгийн харилцан туслалцах Зөвлөлийн гишүүн орнуудын дээд эрхийг барих эрх бүхий байгууллагын зөвлөмж шийдвэр, түүнчлэн ЗСБНХУ-ын туршлага шийдвэрлэх үүрэг, гүйцэтгэж байжээ.

1990-ээд оноос социалист байгууллын тогтолцоо задарч, түүний бүрэлдэхүүнд багтаж байсан олон улс орон зах зээлийн харилцаанд шилжин орох нөхцөл бүрдсэнээр социалист эрх зүйн тогтолцоо өөрчлөгдөх улс, төр эдийн засгийн үндэс суурь тавигджээ. Гэхдээ зах зээлийн харилцааны үеийн эрх зүй нь агуулга хэлбэрийн хувьд өөрчлөгдөн шинэчлэгдсэн ч гэсэн социалист иргэний эрх зүйн харилцаанаас уламжлан авч үлдээсэн олон төрөл зүйлийн харилцаа байгааг хүлээн зөвшөөрч уламжлал-шинэчлэлийн утгаар тайлбарлаж судлах нь зохистой гэж үзнэ.

1940 онд хуралдсан 8 дугаар Их хурлаас баталсан БНМАУ-ын Үндсэн хууль нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийн харилцаанд гарсан гүн гүнзгий өөрчлөлтийг тусгаж хувьсгалын ардчилсан шатнаас социалист байгууллын үр үндсийг хөгжүүлэн бэхжүүлэх шинэ үед шилжин орсныг батлан тунхагласан нь дагаж мөрдөж ирсэн хууль тогтоомжийг өөрчлөн шинэчлэх зайлшгүй хэрэгцээ, шаардлага болсон байна.

1952 онд батлагдсан Иргэний хууль болон Иргэний байцаан шийтгэх хууль нь Монгол улсад социализмын үндсийг үүсгэн байгуулах, социалист аж ахуйн харилцааг төлөвшүүлэн тогтооход чиглэсэн хэм хэмжээ тогтоосон байв. Энэ хуулиар иргэний эрх зүйн харилцааны субъектийг иргэн, хуулийн этгээд гэж ангилж тэдгээрийн нийтлэг эрх, үүргийн чадварыг товч боловч тодорхойлсон, мөн үүргийн эрх зүйн тусгай төрлийг худалдаа, арилжаа, эд хөрөнгө хөлслөх, даалгаврын болон контрактацын зэрэг эдийн засаг, аж ахуйн харилцаанд нэлээд түгээмэл ашиглагдаж байсан гэрээний зарим нөхцөл, шинжийг хуульчлан тогтоосон зэргээрээ онцлогтой байв. Үүнээс гадна гэрээний бус хэлбэрээр үүрэг үүсэх зарим үндэслэлийг тухайлбал, үндэсгүйгээр баяжих, гэм хор учруулснаас үүсэх үүрэг, мөн зохиогч, шинэ бүтээлийн эрхтэй холбогдох үүргийн төрлийг шинээр тусгасан зэрэг тухайн үеийн нийгмийн харилцаанд шаардагдах хэм хэмжээг тогтоон системчилснээрээ иргэний эрх зүйн зохицуулалтын цаашдын хөгжилд чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Социалист иргэний эрх зүйн гол эх сурвалж нь 1963 оны Иргэний хууль байсан ба Энэ хууль нь тус улсад эдийн засаг, аж ахуйн харилцааг социалист ёсоор өөрчлөн байгуулах, социалист төр нь, нийгэм, соёлын болон аж ахуйн байгууллагын эрх ашиг сонирхлыг хамгаалах, ялангуяа социалист өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах онцгой эрх мэдлийг тогтоон, хувийн болон амины өмчийн эрх мэдлийг хязгаарлах зэрэг харилцааг 1960 оны үндсэн хуулийг үндэслэн шууд зохицуулж ирснээрээ социалист иргэний эрх зүйн харилцааг төлөвшүүлэн тогтооход гол үүрэг гүйцэтгэсэн сонгодог хэлбэр, үзэл сурталжсан эрх зүйн нэгж хэсэг байв.

Монгол улсын Иргэний хуулийн гол зорилтыг харьцуулан үзвэл 1963 оны Иргэний хуульд зааснаар “БНМАУ-ын Иргэний хууль нь социалист системийн аж ахуй, социалист өмчийг бэхжүүлэн хөгжүүлэх, социалист байгуулалтаас цаашид коммунизмын байгуулалтад шилжих, иргэдийн эд материалын болон оюун санааны хэрэгцээг дүүрэн хангах зорилгоор эд хөрөнгийн болон түүнтэй холбогдсон эд хөрөнгийн бус харилцааг, хуульд заасан бол эд хөрөнгийн бус амины бусад харилцааг зохицуулна” гэж тодорхойлсон байхад 1994 оны Иргэний хуульд “Иргэний гүйлгээнд оролцогчдын эрх зүйн байдлыг тодорхойлж, эд хөрөнгийн болон түүнтэй холбоотой эд хөрөнгийн бус амины харилцааг, уг харилцаанд оролцогчдын эрх тэгш байдал, хүсэл зоригийн болон эд хөрөнгийн бие даасан байдлыг үндэслэн зохицуулна” гэж тодорхойлжээ.

Энэ тодорхойлолтуудаас үзэхэд 1994 оны Иргэний хууль нь социалист байгуулалтын болон социалист өмчийг хамгаалан бэхжүүлэх, иргэдийн материалын болон оюун санааны хэрэгцээг дүүрэн хангах гэсэн зорилтоос бүрэн татгалзаж харин эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус амины харилцааг уг харилцаанд оролцогчдын эрх тэгш байдал, хүсэл зориг, бие даасан байдлыг хангах зорилтыг гол зорилго болгосноороо зарчмын онцлог ялгаатай байна.

Иргэний хууль тогтоомж нь зорилгоосоо шалтгаалж зохицуулж байгаа харилцааны агуулга, хэлбэр нь үндсээрээ өөр өөр шинж чанарыг илэрхийлнэ. Тухайлбал, иргэний эрх зүйн харилцаа үүсэх үндэслэлийг харьцуулан 1963 оны Иргэний хуульд “улсын төлөвлөгөө, даалгаврыг” нэн чухал байр эзлүүлэн тодорхойлж байсан бол 1994 оны Иргэний хуульд түүнийг хасаж харин иргэний эрх зүйн харилцаа үүсгэхэд чиглэсэн шүүхийн шийдвэрийг нэн чухал үндэслэл болгон тодорхойлсон байх жишээтэй байна.

Социалист байгуулалтын үед эдийн засаг, аж ахуйн харилцааг зохицуулахад төвлөрсөн төлөвлөгөө, хуваарилалт чухал үүрэг гүйцэтгэсэн төдийгүй түүнийг баталгаатай хангах хууль зүйн гол хөшүүрэг нь Монгол Улсын Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Улсын арбитрын газар байсан юм. 1930-аад онд анх үүсэн байгуулагдсан Улсын арбитрын байгууллага социалист үйлдвэр, аж ахуйн байгууллагын хооронд улсын төлөвлөгөө, даалгавар болон гэрээ хэлцлийн замаар үүссэн хэрэг маргааныг иргэний хууль тогтоомж болон арбитрын байгууллагаас аж ахуйн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх хууль, дүрэмд зааснаар нэг үгээр хэлбэл шүүн таслах үүргийг гүйцэтгэж ирсэн байна. Харин 1990-ээд оноос арбитрын байгууллагыг татан буулгаж, түүний үүргийг шүүхэд шилжүүлж гүйцэтгүүлэх болжээ.

Энэ үед иргэний эрх зүйн онол, практикийн судалгаа, эрдэм шинжилгээний ажилд шинэ эхлэл гарч ирснийг зориуд тэмдэглэх нь чухал юм. 1957 онд Хууль цаазын дунд сургуулийн багш Б.Жавзмаа “БНМАУ-ын иргэний эрх” гэсэн товхимол хэвлүүлснийг эрдэмтэн- судлаачид иргэний эрх зүйн анхны бүтээл гэж үнэлж иржээ. Мөн Л.Зэвгээгийн “БНМАУ-ын иргэний эрх зүйн ерөнхий анги” /1975 он/, Д.Зундуй, Л.Чинбат нарын редакторласан хамтын бүтээл “БНМАУ-ын Иргэний эрх зүй” /1988 он/, “БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх эрх зүйн тайлбар” /1984 он/, Т.Мөнхжаргалын “Монгол Улсын Иргэний эрх зүй” /1996-1997 он/, Д.Наранчимэгийн “Иргэний эрх зүйн үндсэн асуудал” /1999 он/ зэрэг бие даасан зохиол бүтээлүүд хэвлэгдэн гарсан нь иргэний эрх зүй судлаачдад

онол практикийн мэдлэг олгох эрдэм шинжилгээний ач холбогдолтой эх сурвалж болжээ.

Түүнчлэн иргэний эрх зүй нь их, дээд сургуулиудад судлах үндсэн суурь хичээлийг нэг болж сургалтын төлөвлөгөөнд тусгагдах болсноор түүний зохицуулах харилцааг улам боловсронгуй болгох шаардлага байнга өндөржсөөр байна.

1963 оны Иргэний хуулийн гол шинжийг Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан нар тодорхойлохдоо: “Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үндсийг бэхжүүлж, өмчийн олон хэлбэрийн адил тэгш хөгжих эрхийг хязгаарлан улмаар улсын өмчийг давуутай хөгжүүлэх, эрх зүйн бааз, суурь нь болсон боловч эд хөрөнгийн бус харилцааны олон төрөл чиглэл, иргэний эрх зүйн харилцааны талууд /субъект/-ын хариуцлагыг дээшлүүлэх, иргэдийн эрх ашиг сонирхлыг хамгаалах хууль зүйн баталгааг хүчтэй болгоход чухал үүрэг гүйцэтгэсэн юм гэж дүгнэжээ.

Нэн шинэ үеийн иргэний эрх зүй /1994 оноос хойших үе/

Монгол Улсад өрнөсөн улс төр, нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, шинэчлэл нь социалист байгуулалтын харилцааг зохицуулж байсан хууль тогтоомжийг үндсээр нь өөрчлөн шинэчлэх бодит шаардлага болсон юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн /1992 оны/ хавсралт хуульд зааснаар хууль тогтоомжийг Үндсэн Хуульд нийцүүлэн бүрэн шинэчлэх асуудлыг 1996 онд багтаан хийж дуусгах зорилт тавигдсан байна.

Үндсэн хуулийн 5 дугаар зүйлд Монгол улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна. Төр нь нийгмийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална гэж тодорхойлон заасан нь иргэний эрх зүйн төдийгүй бусад салбар эрх зүйг шинэчлэх эдийн засгийн эрх зүйн гол үндэслэл болсон байна.

Өнөө үед Монгол улсын хуулиудыг шинэчлэх үйл явц нь эх газрын буюу Ром-Германы эрх зүйгээс гадна, далайн оруудын буюу Англо-Саксоны эрх зүйн тогтолцооны зарим чиг хандлагыг тусган боловсруулснаараа нэлээд онцлогтой гэж зарим судлаачид тэмдэглэсэн байдаг.

1994 онд батлагдсан Иргэний хуулийн гол агуулга нь социалист хэв-маягийн харилцааг халж, өөрчлөх, орчин үеийн олон улсын хөгжлийн түүхэн хандлагын дагуу хүмүүнлэг ардчилсан соёл иргэншлийг төлөвшүүлэн тогтооход чиглэсэн хэм хэмжээг тогтоосноороо онцлог талтай гэж үзэж болно.

Төр, нийгмийн харилцааг өөрчлөн шинэчлэхэд иргэний эрх зүйн гүйцэтгэж ирсэн үүргийг түүхчлэн судлах явдал чухал ач холбогдолтой юм. Тухайлбал, Монгол Улсын эдийн засаг, аж ахуйн харилцаа, өмч, өмчлөх эрх үүргийн талаар явуулсан төр нийгмийн бодлого нь иргэний эрх зүйн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжид бүрэн тусгалаа олж нийгмийн амьдралд хэрэгжүүлж ирснийг тэмдэглэвэл зохино.

Дүгнэлт:

Монгол улсын тухайд өнгөрч байгаа 20-р зууны түүхэнд өмч, өмчлөх эрхийн үндсэн дөрвөн хэлбэрийг дамжин хөгжиж ирсэн хэмээн тодорхойлж болох юм.

Нэгдүгээр үе буюу 1920-иод он хүртэлх хугацаанд тухайн цаг үеийн шинжлэх ухаан техникийн хөгжлөөс хоцрогдсон арга, ажиллагаатай зөвхөн амь, хувиа аргацаах байдалтай энгийн нөхөн үйлдвэрлэлийн шинжтэй, нүүдлийн мал аж ахуй зонхилсон сүм хийдийн болон зарим ноёд, феодалын эрх мэдэлд хамаарах төдий хувийн өмчийн хэлбэрт тулгуурласан.

Хоёрдугаар үе буюу /1920-1940-өөд онд/ сүм хийд, ноёд феодалын хувийн өмчийг улсын болгох, үндэсний үйлдвэрлэл, аж ахуйн газрыг үүсгэн байгуулж улмаар социализмын эдийн засаг, аж ахуйн харилцааг тогтоон төлөвшүүлэхэд чиглэсэн хууль тогтоомжоор зохицуулж байв.

Гуравдугаар үе буюу 1940-60-аад онд мал, газар тариалан зэрэг хөдөө аж ахуйн салбарыг хоршоолон нэгтгэх улсын болгох замаар хувийн өмчийн хэлбэрийг үндсэнд нь бүрэн халж улсын болон хоршооллын хэлбэрээс бүрдэх социалист өмчийн харилцааг тогтоох улмаар 1960-аад оноос 1990 –ээд он хүртэл Монгол улсад амины болон социалист өмч гэсэн хоёр хэлбэрээр эдийн засаг, аж ахуйн харилцаа бүрэн ноёрхох болж түүнийг төлөвшүүлж тогтоох асуудалд иргэний эрх зүй шууд зохицуулах үүрэг гүйцэтгэж иржээ.

Дөрөвдүгээр үе буюу 1990-ээд оноос Үндсэн хуулиар тогтоосон зарчмаас үндэслэж, 1994 онд баталсан иргэний хууль нь социалист өмчийн хэлбэр төрлийг бүрэн халж зах зээлийн харилцаанд тохирч нийцсэн өмчийн хэлбэр төрөл түүнчлэн өмчлөх эрхийн агуулгыг үндсээр нь өөрчлөн зохицуулах эрх зүйн гол эх сурвалжийн нэг болсон юм. Тус улсад хувийн, нийтийн гэсэн өмчийн хоёр хэлбэр эрчимтэй хөгжиж социалист хэмээн нэрлэж байсан өмч, түүнийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх нь гагцхүү төрийн мэдэлд үлдэж улмаар түүнийг “хувьчлах” аргаар хувийн буюу холимог өмчийн хэлбэр төрөлд шилжүүлэх үйл ажиллагаа явагдаж байсан.

Нөгөө талаар Монгол Улсын Иргэний хуульд нийтийн өмчийн төрийн аж ахуйн нэгжийн /нөхөрлөл, компани, хоршоо, холбооны гэх мэт/ төрийн бус соёл гэх мэт түүнчлэн гадаадын иргэд, хуулийн этгээд, олон улсын байгууллагын гэх мэт олон төрөлд ангилан үзэж тэдгээрийн эрх мэдлийн хэмжээ хязгаарыг хуульчлан тогтоосон салбар эрх зүйн эх сурвалжийн нэг болов.

Үүнтэй холбогдуулж иргэний эрх зүйгээр зохицуулж байгаа харилцааг үүсэн гарч байгаа иргэний хэрэг маргааны төрөл зүйлийг Улсын Дээд шүүхийн дараах архивын баримт мэдээнээс харьцуулан үзэж дүгнэлт хийж болно. Тухайлбал, социалист нийгмийн харилцааны эд өрнөлийн үе буюу 1979 онд тус улсын нийт шүүхийн хэмжээгээр 14038 Иргэний хэрэг шийдвэрлэж байсан бол зах зээлийн харилцаанд шилжсэн үеийн 10 дахь жил буюу 1999 онд 28039 Иргэний хэрэг шийдвэрлэсэн нь өмнөх 20 дахь жилээс хоёр дахин өссөн байна.

Энэ тооноос үзвэл тус улс зах зээлийн харилцаанд шилжин орсон энэ үед Иргэний хууль тогтоомжоор зохицуулж байгаа харилцаа үлэмж өргөжсөн гэдэг нь харагдаж байна. Нөгөө талаар түүнийг зөрчиж гажуудуулснаас шүүхэд гомдол,

нэхэмжлэл гаргах явдал их өссөнийг харуулж байна. Шүүхээс хянан шийдвэрлэж байгаа иргэний хэргийн дотроос голлон зөрчигдөж байгаа харилцааны төрлөөр үзвэл 1999 онд шүүхээр шийдвэрлэсэн бүх иргэний хэргийн 54 хувийг иргэд, албан газар, хуулийн этгээд, тэдгээрийн хооронд үүссэн эд хөрөнгө, аж ахуйн үйл ажиллагаанаас үүссэн хэрэг бараг 10 хувийг гэрлэлт цуцлуулсан, хүүхдийн тэтгэлэг тогтоосон зэрэг гэр бүлийн харилцаанаас үүссэн хэрэг, 5 хувийг ажлаас буруу халсан, цалин хөлс дутуу олгосон зэрэг хөдөлмөрийн эрх зүйн харилцаанаас үүссэн хэрэг тус тус эзэлж байна. Иргэний хэргийн гаралтын тоо хэмжээ аймаг, хотуудад харилцан адилгүй байна.

2002 оны Иргэний хууль нь шинэ зуунд Монгол Улсын эдийн засаг, нийгмийн харилцааг олон улсын зах зээлийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн даяарчлалын хэм хэмжээний хүрээнд улам ойртуулан зохицуулах нөхцөл боломжийг бүрдүүлж өгснөөрөө онцгой ач холбогдолтой хууль болсон юм.

Санал:

2002 оноос хойш буюу нэн шинэ үеийн Иргэний хууль батлагдсанаас хойш эдүгээ 21 жил өнгөрсөн байна. Дээрх хуулиуд батлагдсан цаг үеэс хойш бид хувийн эрх зүйд дараах байдлаар шинэтгэл хийх, түүнийг төгөлдөржүүлэх шаардлагатай байна.

1. Даяарчлалын энэ эрин зуунд нийгэм эдийн засгийн харилцаа нэг улсын хил хязгаараас хальж улс орнууд улам бүр ойртон нягтрах үйл явц нийгмийн амьдралын бүхий л хүрээг хамарч, энэ нь улс орнуудын эрх зүйн тогтолцоонд ч харилцан нөлөөлж байна. Хувийн эрх зүйн энэхүү даяаршлын үйл явц нь төрөл бүрийн эрсдэлийг дагуулж буйг анхаарах нь зүйтэй. Монгол улсад худалдаа арилжаатай холбоотой харилцааг Иргэний хууль болон Нөхөрлөлийн тухай, Компанийн тухай хууль, Өрсөлдөөний тухай, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай, Дампуурлын тухай гэх мэт хуулиар зохицуулж байгаа хэдий ч аж ахуй, бизнес эрхлэгчдийн хооронд үүссэн харилцааг цогц байдлаар зохицуулсан эрх зүйн тогтолцоо байхгүй байна. Өөрөөр хэлбэл Иргэний хуульд аж ахуй эрхлэгч болон хэрэглэгч хоорондын, эсхүл иргэд хоорондын харилцааг илүүтэйгээр зохицуулсан бөгөөд аж ахуй эрхлэгчдийн хооронд үүсэх бизнесийн онцлог харилцааг зохицуулсан хэмжээг эдийн засгийн агуулгаар баяжуулах, бие даасан эдийн засгийн эрх зүй буюу арилжааны эрх зүйг бий болгох шаардлагатай байгаа юм.

2. Ажил гүйцэтгэх гэрээтэй холбоотой барилгын хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэж байгаа практикийг харахад түүний үнэлгээг тогтооход шинжээч нар ихээхэн үүрэгтэй оролцох ёстой атал тэдгээрийн оролцоог хангахад зарим талаар хүндрэлтэй асуудлууд гардаг. Тиймээс одоогийн шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнгийн шинжээчдийг энэ чиглэлээр мэргэшүүлэх, энэ чиглэлийн тусгайлсан бүтцийн нэгж байгуулах хэрэгтэй байна.

3. Иргэний эрх зүйн шинэтгэлийн хүрээнд анхаарал хандуулах нэг зүйл бол гэм хорын асуудал юм. Тухайлбал: эрүүл мэндийн ажилтнууд өвчтөнд

хайхрамжгүй хандах, хүний биед гэмтэл учруулах, хүний амь насанд хохирол учруулах байдлууд нэмэгдсээр байх тул тэдгээрийг гэм хорын зөрчилд тооцож хариуцлага тооцох механизмыг иргэний хуульд оруулах нь зүйтэй.

4. Дэлхий нийтийн чиг хандлагаас харвал хувийн эрх зүйд тэр дундаа иргэний эрх зүйд сансрын эрх зүй, компанийн эрх зүй, үнэт цаасны эрх зүй, эрчим хүчний эрх зүй, мэдээллийн эрх зүй, хэвлэл мэдээллийн эрх зүй, интернэтийн эрх зүй, өрсөлдөөний эрх зүй зэрэг шинэ төрлийн дэд салбарууд хөгжиж байна. Манай улсад ч гэсэн эдгээр салбаруудыг хөгжүүлэх хэрэгцээ шаардлагатай байгаа юм.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

1. Э.Авирмэд, Д.Дашцэдэн. Монгол хууль. Уб., 1997.
2. Т.Алтангэрэл. Монгол ойрадын их цааз, түүний судалгаа Уб. 1998.
3. С.Нарангэрэл. Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо Уб. 2001.
4. Б.Баярсайхан. Монгол цаазын товчоон. Уб., 2001.
5. Н.Лүндэндорж. Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал, шинэчлэлийн зарим асуудал. Уб., 2001.
6. Б.Баярсайхан. Хууль зүйн тайлбар толь /Монгол улсын төр, эрх зүйн түүх/. Уб., 2003.
7. Г.Баярхүү. Монголын нэгдсэн төрийн болон дараах үеийн хууль цааз, заншлын хэм хэмжээг харьцуулан судалсан нь. Уб., 1997.
8. Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан. Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. Уб., 1997.
9. Т.Мөнхжаргал. Монгол улсын иргэний эрх зүй. Уб., 2000.
10. Т.Мөнхжаргал. Монгол улсын иргэний цаазын товчоон. Уб., 2006.

---o0o---